

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2026/015/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
НЭГДҮГЭЭР СУРГУУЛИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2026 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор: Б.Адъяасүрэн

Утас: 70273204 Цахим хаяг: adiyasuren@audit.gov.mn

Гэрээгээр гүйцэтгэсэн:

Уваа уул аудит ХХК, захирал: Ч.Мөнхтуяа

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582. Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

Алд. 02. 25 № 01/181
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
НЭГДҮГЭЭР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Д.ӨЛЗИЙБАЯР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Хүүхдийн хоолны түүхий эдийн зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 254 дүгээр тогтоолоор Ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн хүүхдийн нэг өдрийн үдийн хоолны түүхий эдийн зардлыг 2.5 мянган төгрөг, дотуур байранд амьдрах дунд болон ахлах ангийн хүүхдийн нэг өдрийн хоолны түүхий эдийн зардлыг 6.3 мянган төгрөг, бага ангийн хүүхдийн нэг өдрийн хоолны түүхий эдийн зардлыг 6.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон байна.

Аудитын гол асуудал

Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын сургуулийн 100 жилийн ойн хүрээнд үе үеийн төгсөгчдөөс нийт 163,644.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хандивлаж, данс бүртгэл тусгасан байна.

Бусад асуудлын хэсэг

Төв аймгийн Засаг даргын Тамгын газраас орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Хүүхдийн автобус хөтөлбөр”-ын хүрээнд ТӨАХААГ/20240102068 дугаартай худалдан авах ажиллагааг зохион байгуулж, “Хаштехник” ХХК шалгарч нэг

4126020166

Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

бүр нь 57,497.0 мянган төгрөгийн өртөгтэй БНХАУ-д үйлдвэрлэсэн хүүхдийн шар автобусыг 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдөр хүлээлгэн өгсөн байна.

Хүүхдийн шар автобусны суудлын хэмжээ нь бага ангийн сурагч суух боломжгүй жижиг, техникийн шаардлага хангахгүй, эвдрэлтэй байсан тул Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын нэгдүгээр сургууль нь замын хөдөлгөөнд оролцуулаагүй бүртгэлд тусгаагүй байна.

Тус байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилт бүхий нийт 45 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 91,0 хувиар үнэлэгдсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	608,666,143.51	746,808,104.44
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	377,721,684.00	495,620,345.91
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	377,721,684.00	495,620,345.91
3121	Төгрөг	377,721,684.00	495,620,345.91
31211	Төрийн сангийн харилцах	377,721,684.00	495,620,345.91
33	АВЛАГА	-	9,372,350.00
335	Бусад авлага	-	9,372,350.00
3351	Байгууллагаас авах авлага	-	9,372,350.00
35	БАРАА МАТЕРИАЛ	230,944,459.51	241,815,408.53
351	Түүхий эд материал	681,390.00	-
35130	Эм боох материал	681,390.00	-
354	Хангамжийн материал	221,733,069.51	231,745,408.53
35420	Аж ахуйн материал	2,947,820.00	-
35450	Барилгын засварын материал	890,000.00	-
35460	Хүнсний материал	3,384,652.00	19,268,150.00
35470	Бусад хангамжийн материал	214,510,597.51	212,441,258.53
35600	Мал амьтад	8,530,000.00	10,070,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,112,946,614.51	4,548,779,159.82
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,112,946,614.51	4,548,779,159.82
392	Биет хөрөнгө	4,073,902,781.23	4,510,121,659.94
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,800,865,800.60	4,154,261,326.60
39202	Хуримтлагдсан элэгдэл	(169,534,682.15)	(232,882,445.51)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	5,500,000.00	5,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(5,500,000.00)	(5,500,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	400,640,188.00	429,984,284.70
39206	Хуримтлагдсан элэгдэл	(153,450,488.71)	(193,225,627.85)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	248,684,953.00	314,892,289.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	(112,635,509.29)	(89,413,404.91)
39214	Бусад үндсэн хөрөнгө	105,668,654.00	150,668,654.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(61,865,135.22)	(37,614,417.69)
39217	Ном	15,529,001.00	13,451,001.00
393	Биет бус хөрөнгө	39,043,833.28	38,657,499.88
39301	Програм хангамж	1,284,000.00	1,284,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(478,166.72)	(864,500.12)
39303	Бусад биет бус хөрөнгө	38,238,000.00	38,238,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,721,612,758.02	5,295,587,264.26
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	7,488,986.73
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	7,488,986.73
413	Өглөг	-	7,488,986.73
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	3,625,637.43

Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

4136	Бусад өглөг	-	3,863,349.30
41361	Байгууллагад төлөх өглөг	-	3,863,349.30
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,721,612,758.02	5,288,098,277.53
51	Засгийн газрын хувь оролцоо	4,721,612,758.02	5,288,098,277.53
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	549,958,766.20	549,958,766.20
51101	Өмч: - төрийн	549,958,766.20	549,958,766.20
512	Хуримтлагдсан үр дүн	2,788,507,590.56	3,354,993,110.07
51210	Өмнөх үеийн үр дүн	2,788,507,590.56	2,788,507,590.56
51220	Тайлант үеийн үр дүн	-	566,485,519.51
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,383,146,401.26	1,383,146,401.26
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,721,612,758.02	5,295,587,264.26

Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,143,409,877.60	4,066,493,027.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,258,511,677.60	666,805,627.70
120	Нийтлэг татварын бус орлого	2,258,511,677.60	464,923,267.70
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,258,511,677.60	464,923,267.70
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,117,200.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,130,000.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	2,255,254,477.60	446,757,369.70
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		18,165,898.00
122	Тусламжийн орлого	-	201,882,360.00
122001	Хандив тусламж /дотоод/	-	201,882,360.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	358,464,500.00	3,399,687,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,526,433,700.00	3,065,690,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,526,433,700.00	3,065,690,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	358,464,500.00	333,997,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,758,033,584.36	3,496,650,508.19
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,758,033,584.36	3,496,650,508.19
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,651,292,280.54	3,375,807,508.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,736,519,292.07	2,216,152,739.14
210101	Үндсэн цалин	1,083,001,870.68	1,326,686,917.59
210102	Нэмэгдэл	600,220,369.14	797,457,467.55
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	33,955,000.00
210104	Урамшуулал	53,297,052.25	58,053,354.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	210,197,278.84	268,249,878.38
210201	Тэтгэврийн даатгал	144,217,416.27	185,270,041.73
210202	Тэтгэмжийн даатгал	17,211,814.80	22,541,034.96
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,643,264.29	11,485,918.29
210204	Ажилгүйдлийн даатгал	8,249,063.50	9,799,439.27
210205	Эрүүл мэндийн даатгал	31,875,719.98	39,153,444.13
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	325,940,080.94	333,278,321.28
210301	Гэрэл, цахилгаан	19,166,765.94	28,131,329.28
210302	Түлш, халаалт	306,773,315.00	303,646,992.00
210303	Цэвэр, бохир ус	-	1,500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	104,490,705.98
210401	Бичиг хэрэг	-	2,721,450.00
210402	Тээвэр, шатахуун	-	15,424,589.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	7,756,210.00
210408	Бараа материал акталсны зардал	-	78,588,456.98
2105	Нормативт зардал	113,094,200.00	157,302,958.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	530,300.00
210502	Хоол, хүнс	113,094,200.00	156,772,658.00

**Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	3,000,000.00	5,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	4,279,681.00
210702	Дотоод албан томилолт	-	4,279,681.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,164,044.79	47,728,380.02
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,117,200.00	3,687,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	1,612,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	22,046,844.79	42,427,980.02
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	238,377,383.90	239,324,844.39
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	74,909,580.00	18,607,380.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	19,023,550.00	17,184,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	144,444,253.90	203,533,064.39
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	106,741,303.82	120,843,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	104,441,200.00	120,843,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	82,465,500.00	120,843,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	21,975,700.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,300,103.82	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,300,103.82	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	2,385,376,293.24	569,842,519.51
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	720,000.00	650,000.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	720,000.00	650,000.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	4,007,000.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	4,007,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	720,000.00	(3,357,000.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	2,386,096,293.24	566,485,519.51

Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,887,315,400.00	3,399,687,400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,417,200.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	2,417,200.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,417,200.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,117,200.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	300,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,884,898,200.00	3,399,687,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,526,433,700.00	3,065,690,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,526,433,700.00	3,065,690,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	358,464,500.00	333,997,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	358,464,500.00	333,997,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,712,351,877.70	3,248,817,958.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,712,351,877.70	3,248,817,958.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,605,610,573.88	3,124,556,958.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,736,428,808.77	2,213,784,279.81
210101	Үндсэн цалин	1,083,001,870.68	1,324,927,001.71
210102	Нэмэгдэл	600,129,885.84	798,862,505.98
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	33,258,874.81
210104	Урамшуулал	53,297,052.25	56,735,897.31
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	210,287,762.14	270,618,337.71
210201	Тэтгэврийн даатгал	144,217,416.27	187,373,250.69
210202	Тэтгэмжийн даатгал	17,211,814.80	22,537,978.75
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,643,264.29	11,484,390.19
210204	Ажилгүйдлийн даатгал	8,249,063.50	9,828,005.47
210205	Эрүүл мэндийн даатгал	31,966,203.28	39,394,712.61
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	353,164,396.18	328,997,000.00
210301	Гэрэл, цахилгаан	18,085,886.48	28,131,329.28
210302	Түлш, халаалт	333,997,630.24	300,021,354.57
210303	Цэвэр, бохир ус	1,080,879.46	844,316.15
2105	Нормативт зардал	113,830,582.00	175,457,412.00
210502	Хоол, хүнс	113,830,582.00	175,457,412.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	3,000,000.00	5,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	49,301,924.79	46,061,008.57
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,117,200.00	3,687,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	47,184,724.79	42,373,408.57
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	139,597,100.00	84,638,920.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	119,187,100.00	68,039,520.00

**Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	20,410,000.00	16,599,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	106,741,303.82	124,261,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	104,441,200.00	124,261,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	82,465,500.00	124,261,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	21,975,700.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,300,103.82	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,300,103.82	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	174,963,522.30	150,869,441.91
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	32,970,780.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	32,970,780.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	32,970,780.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	32,970,780.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(32,970,780.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	174,963,522.30	117,898,661.91
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	202,758,161.70	377,721,684.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	377,721,684.00	495,620,345.91

Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	549,958,766.20	1,383,146,401.26	402,411,297.32	2,335,516,464.78
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	549,958,766.20	1,383,146,401.26	402,411,297.32	2,335,516,464.78
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	2,386,096,293.24	2,386,096,293.24
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	549,958,766.20	1,383,146,401.26	2,788,507,590.56	4,721,612,758.02
2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	549,958,766.20	1,383,146,401.26	2,788,507,590.56	4,721,612,758.02
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	549,958,766.20	1,383,146,401.26	2,788,507,590.56	4,721,612,758.02
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	566,485,519.51	566,485,519.51
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	549,958,766.20	1,383,146,401.26	3,354,993,110.07	5,288,098,277.53

Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,835,037,100.00	3,399,687,400.00	435,349,700.00	88.65
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,124,356,300.00	3,065,690,400.00	58,665,900.00	98.12
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,124,356,300.00	3,065,690,400.00	58,665,900.00	98.12
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	333,997,000.00	333,997,000.00	-	100.00
132001	Орон нутгийн төсвөөс	333,997,000.00	333,997,000.00	-	100.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	376,683,800.00	-	376,683,800.00	-
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	376,683,800.00		376,683,800.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,835,037,100.00	3,281,788,738.09	553,248,361.91	85.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,835,037,100.00	3,281,788,738.09	553,248,361.91	85.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,700,099,800.00	3,157,527,738.09	542,572,061.91	85.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,696,760,300.00	2,213,784,279.81	482,976,020.19	82.09
210101	Үндсэн цалин	1,649,907,700.00	1,324,927,001.71	324,980,698.29	80.30
210102	Нэмэгдэл	995,071,800.00	798,862,505.98	196,209,294.02	80.28
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	33,258,874.81	(33,258,874.81)	
210104	Урамшуулал	51,780,800.00	56,735,897.31	(4,955,097.31)	109.57
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	337,095,200.00	270,618,337.71	66,476,862.29	80.28
210201	Тэтгэврийн даатгал	229,224,700.00	187,373,250.69	41,851,449.31	81.74
210202	Тэтгэмжийн даатгал	26,967,700.00	22,537,978.75	4,429,721.25	83.57
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,483,800.00	11,484,390.19	1,999,409.81	85.17
210204	Ажилгүйдлийн даатгал	13,483,800.00	9,828,005.47	3,655,794.53	72.89
210205	Эрүүл мэндийн даатгал	53,935,200.00	39,394,712.61	14,540,487.39	73.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	328,997,000.00	328,997,000.00	-	100.00
210301	Гэрэл, цахилгаан	25,350,000.00	28,131,329.28	(2,781,329.28)	110.97
210302	Түлш, халаалт	303,647,000.00	300,021,354.57	3,625,645.43	98.81
210303	Цэвэр, бохир ус	-	844,316.15	(844,316.15)	
2105	Нормативт зардал	179,844,900.00	175,457,412.00	4,387,488.00	97.56
210502	Хоол, хүнс	179,844,900.00	175,457,412.00	4,387,488.00	97.56
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	5,000,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	5,000,000.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	49,771,000.00	55,411,008.57	(5,640,008.57)	111.33
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,435,000.00	3,687,600.00	3,747,400.00	49.60
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	42,336,000.00	51,723,408.57	(9,387,408.57)	122.17
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	102,631,400.00	108,259,700.00	(5,628,300.00)	105.48
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	87,838,800.00	91,075,300.00	(3,236,500.00)	103.68
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,792,600.00	17,184,400.00	(2,391,800.00)	116.17
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	134,937,300.00	124,261,000.00	10,676,300.00	92.09
2132	Бусад урсгал шилжүүлэг	134,937,300.00	124,261,000.00	10,676,300.00	92.09
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	134,937,300.00	124,261,000.00	10,676,300.00	92.09
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		377,721,684.00		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		495,620,345.91		

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой 5,939,543.0 мянган төгрөгийн алдаа илэрснийг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

Санхүүгийн мөнгөн гүйлгээний тайланд худалдан авсан 7,684.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардалд тайлагнаагүй.

Санхүүгийн үр дүнгийн тайланд 330.3 мянган төгрөгийн эм боох материал, 1,692.8 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 5,296.0 мянган төгрөгийн аж ахуйн материал, 3,823.2 мянган төгрөгийн дотоод албан томилолтын зардлыг бусад зардалд тайлагнасан.

Санхүүгийн үр дүнгийн тайланд 7-9 дүгээр сарын үндсэн хөрөнгийн 48,861.7 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг бүртгээгүй.

Өмчийн өөрчлөлтийн тайлангийн өмнөх оны тайлангийн үзүүлэлт 5,288,098.3 мянган төгрөгийг тайлагнаагүй.

Санхүүгийн үр дүнгийн тайланд 584,053.8 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал, үндсэн хөрөнгө, хандиваар авсан хөрөнгөд бүртгэснийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна", 15.2-т "нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Аудитаар илэрсэн 12,525.4 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 34,966.5 мянган төгрөгөөс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

Аудитаар нийт 12,525.4 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 3 зөвлөмж өглөө.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу Санхүүгийн тайлангийн мэдээлэл агуулсан тодруулга тайлан бэлтгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна", 8.1.5-д "Санхүүгийн тайлангийн тодруулга", Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 8.3-д "Санхүүгийн тайлангийн тодруулга нь Санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд толилуулаагүй боловч тэдгээрийн аль нэгийг ойлгоход хамааралтай нэмэлт мэдээллээр хангана" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайланг тайлбар тодруулгын хамт бэлтгэж байх.

2. Авлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Дотуур байранд байрладаг сурагчдын хоолны түүхий эд худалдан авах зардалд 9,372.4 мянган төгрөг илүү шилжүүлэн авлага үүсгэсэн.

**Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулж, авлага үүсгэхгүй ажиллах.

Өглөг холбоотой асуудал

Илрүүлэлт:

Бага ангийн сурагчдын үдийн хоолны түүхий эд худалдан авах хүнсний зардалд 3,153.1 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сурагчдын хоолны зардал хүрэлцээтэй үед өр төлбөр үүсгэхгүй ажиллах.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг 2026 оны 6 дугаар сарын 10-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
								Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Санхүүгийн мөнгөн гүйлгээний тайланд худалдан авсан 7,684.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардалд тайлагнаагүй.	1	7,684.0	1	7,684.0			1	7,684.0		
2	Санхүүгийн үр дүнгийн тайланд 330.3 мянган төгрөгийн эм боох материал, 1,692.8 мянган төгрөг бичиг хэргийн материал, 5,296.0 мянган төгрөгийн аж ахуйн материал, 3,823.2 мянган төгрөгийн дотоод албан томилолтын зардлыг бусад зардалд тайлагнасан.	1	10,845.2			1	10,845.2	1	10,845.2		
3	Санхүүгийн үр дүнгийн тайланд 7-9 дүгээр сарын үндсэн хөрөнгийн 48,861.7 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг бүртгээгүй.	1	48,861.7	1	48,861.7			1	48,861.7		
4	Өмчийн өөрчлөлтийн тайлангийн өмнөх оны тайлангийн үзүүлэлт 5,288,098.3 мянган төгрөгийн тайлагнаагүй.	1	5,288,098.3	1	5,288,098.3			1	5,288,098.3		
5	Санхүүгийн үр дүнгийн тайланд 584,053.8 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал, үндсэн хөрөнгө, хандиваар авсан хөрөнгөд бүртгэсэн.	1	584,053.8			1	584,053.8	1	584,053.8		
	Дүн	5	5,939,543.0	3	5,344,644.0	2	594,899.0	5	5,939,543.0		

Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу Санхүүгийн тайлангийн мэдээлэл агуулсан тодруулга тайлан бэлтгээгүй байна.	1						1					
2	Дотуур байранд байрладаг сурагчдын хоолны түүхий эд худалдан авах зардалд 9,372.4 мянган төгрөг илүү шилжүүлэн авлага үүсгэсэн.	1	9,372.3					1	9,372.3				
3	Бага ангийн сурагчдын үдийн хоолны түүхий эд худалдан авах хүнсний зардалд 3,153.1 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн.	1	3,153.1					1	3,153.1				
	Дүн	3	12,525.5					3	12,525.5				

Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Хуулийн хэрэгжилтийг шалгахад нийт 171 мэдээлэл байршуулахаас хугацаандаа мэдээлсэн 145 мэдээлэл, хугацаа хоцорч мэдээлсэн 14 мэдээлэл, байршуулаагүй 12 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг байршуулахаас орлогын 238,737.1 мянган төгрөгийн 9 гүйлгээ, зарлагын 170,962.3 мянган төгрөгийн 15 гүйлгээ хугацаа хоцорч, орлогын 24,039.4 мянган төгрөгийн 1 гүйлгээ байршуулаагүй. Мөн шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэр эх хуулбарыг тус тус байршуулаагүй байна.	1	433,738.8					1	433,738.8
Дүн	1	433,738.8					1	433,738.8
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Тайлант онд нийт 23,229.0 мянган төгрөгийн компьютер, зурагт худалдан авалт хийхдээ тендер зарлаагүй шууд худалдан авалт хийсэн.	1	23,229.0					1	23,229.0
Дүн	1	23,229.0					1	23,229.0
Нийт дүн	2	456,967.8					2	456,967.8

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn